



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 9
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	10 - 37

- 1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/* 12 - 13
 - 2. “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий/* 13 - 16
 - 3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлт* 16 - 17
 - 4. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/* 17 - 27
 - 5. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 28 - 37
-

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 11 дүгээр сарын 15-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 21 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Өнөрболор;

Чөлөөтэй: Ж.Ганбаатар, Н.Ганибал, Б.Жавхлан, С.Чинзориг, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Оюунчимэг.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байришиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг санал хэлэв.

Ц.Цэрэнпунцаг: Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн ажиллах хугацааг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл сунгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан Ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Бямбадулам, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Ж.Ичинноров, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга Н.Мөнхбаяр, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Ч.Батзориг, Хот байгуулалт хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Хан-Уул, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч Д.Авирмэд, Нийслэлийн Орон Сууцны Корпораци хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

-Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

-Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Э.Борхүү, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Монголбанкны хэвлэл мэдээллийн ажилтан Д.Ариунаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Ч.Хүрэлбаатар, Х.Ганхуяг нар үг хэлэв.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг; 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Г.Амартүвшин, Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Доржханд, С.Чинзориг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төсөлд 2 дугаар заалт нэмэх:

“2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

1/Засгийн газраас эрх зүйн орчныг бүрдүүлж, орон сууцны ипотекийн хөтөлбөрийг шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;

2/Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэнцүү хуваарилах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 3 дугаар дэд заалт нэмэх.

3/Агаар, орчны бохирдлыг бууруулах, төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц, гэр хорооллын барилгажуулалтад олгох ипотекийн зээлийн хэмжээг хөтөлбөрийн нийт эх үүсвэрийн 20 хүртэл хувьд хүргэх арга хэмжээ авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 1 дүгээр заалтад доор дурдсан агуулгатай 1.3 дахь заалт нэмэх:

“1.3.Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бизнесийн зээлийг нэмэгдүүлэх, хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 2.4 дэх заалт нэмэх:

“2.4.Банкнаас жижиг, дунд бизнест олгосон зээлийг ангилах, ангилал дээшлүүлэх, түүний бүтцийг өөрчилж, дахин санхүүжүүлэх зохицуулалтыг эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчимд тулгуурлан уян хатан болгох ажлыг судлан шийдвэрлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 3 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 3.3 дахь заалт нэмэх:

“3.3 Тогтвортой хөгжлийн зорилтын таксономид органик хүнсний тариалалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тодорхой тусгаж, төрийн дэмжлэгтэй хэрэгжиж буй зээл, санхүүжилтийн хөтөлбөрүүдийн багцын тодорхой хэсгийг тухайн таксономитой уялдуулан ногоон, тогтвортой зээл гаргадаг болох чиглэлээр санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 12 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
15 цаг 21 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн гадаадад томилолттой байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн өвчтэй байна.

2 гишүүнээс бусад нь ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 11 дүгээр сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёр. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Улсын Их Хурлын 2023 оны 63 дугаар тогтоолоор байгуулагдсан төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой зарим компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо.

Гурав. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах. Эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах.

Дөрөв. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд.

Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Тав. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Монгол банк банк 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн. Анхны хэлэлцүүлэг гэсэн 5 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? О.Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл гишүүний микрофоныг нээе.

О.Цогтгэрэл: Хэлэлцэх асуудал дээр нэг санал байна.

Юу вэ гэхээр Эдийн засгийн байнгын хорооны 6 дугаар сарын 27-ны хурлаар КОВИД-ын асуудлаарх ерөнхий хяналтын сонголт хийх Эдийн засгийн байнгын хорооны тогтоол гарсан.

Энэ тогтоолын хэрэгжилт, сонголт болох асуудал дээр бас хууль эрх зүйн маргаанууд гарсан.

Сонголт хийх ажлын хэсгийн зүгээс энэ 20 их наядын байж болох энэ дүн бүхий том мөнгөн дүнтэй асуудал дээр шинжээч томилуулж байж ажиллахгүй бол үүн дээр тийм сонголыг чанартай явуулах нэгдүгээрт нь боломж бололцоо алга.

Хоёрдугаарт нь, мөнгөн дүн бүхий асуудал дээр Улсын Их Хурлын гишүүд ярина гэдэг нь өөрөө бас үндэслэлгүйгээр хэн нэгэн рүү улс төрийн зорилгоор ярих боломж бололцоог бүрдүүлээд байна.

Ийм учраас заавал шинжээч томилж өг өө гэдэг шаардлага тавьсан.

Эдийн засгийн байнгын хорооноос шинжээч томилох хууль, эрх зүй байхгүй гэдэг тайлбарыг хэлсэн.

Улсын Их Хурлын Хяналт шалгалтын хэлтсээс шинжээч томилох хуулийн үндэслэлүүд байна гэдэг маргаанууд гарсан учраас тухайн үеийн ерөнхий хяналтын сонголт зохион байгуулагдаагүй.

Ийм учраас Эдийн засгийн байнгын хорооны тогтоолыг биелүүлэхийн тулд дахиад Улсын Их Хурлын Хууль эрх зүйн хэлтэст хэлэхээр бид хууль, эрх зүйн гаргалгаа гаргаж өгөөч гэдэг хүсэлт тавьсан. Ажлын хэсгийн зүгээс.

Тэгэхэд үүнийг Эдийн засгийн байнгын хороогоороо байгуулагдсан ажлын хэсэг учраас Эдийн засгийн байнгын хорооноосоо энэ хүсэлтийг бид бүгдэд хууль эрх зүйн дүгнэлт болоод эрх зүйн гаргалгаа гэдэг утгаараа бид нарт ханд гэдэг, Эдийн засгийн байнгын хороогоор заавал шийдүүлэх ёстой гэдэг ийм шаардлагыг тавьсан.

Ийм учраас өнөөдрийн хэлэлцэх асуудалд саяын тэр хууль, эрх зүйн дүгнэлт гаргах шинжээч тавих асуудал дээр хууль эрх зүйн гаргалгаа гаргах.

Зөвхөн хууль эрх зүйн дүгнэлт гэхчээр бид хууль тайлбарлах боломжгүй гэдэг үүднээс өмнөөс тайлбар хийх юм билээ.

Тэгэхээр эрх зүйн гаргалгаа гаргаж өгөх хүсэлтийг Эдийн засгийн байнгын хорооны зүгээс хэлэлцэх асуудалдаа оруулаад шийдүүлж Улсын Их Хурлын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэхийг хүсье.

Хэлэлцэх асуудалд ийм зүйл нэмэх хүсэлт байна.

Ц.Цэрэнпунцаг: О.Цогтгэрэл даргын ажлын хэсгээс ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээж авсан.

Одоо энэ дээр хариу өгөхөөр бэлтгэж байгаа. Удахгүй хариуг нь өгнө. Энэ төсөлд хариу бэлтгэж байгаа.

Тэгээд дараагийн Байнгын хорооны хуралдаанаар цөмөөрөө энэ асуудлыг хэлэлцье. Энэ дээр албан хариу удахгүй өгнө.

Хэлэлцэх асуудалдаа орё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

*/Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
11 дугаар сард хэлэлцэх асуудлын
цаглавар батлах тухай/*

Хэлэлцэх асуудал.

Нэг.2023 оны 11 дүгээр сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг та бүхэндээ танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр

сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 173 дугаар захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2.Хууль хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т үүрэг болгосугай.

Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Санал хураалт. Гишүүд санал хураалт явуулж эхэлье.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 11 дүгээр сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 60.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 11 дүгээр сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Дараагийн асуудалдаа орёе.

**Хоёр. “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоол**

/Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий/

Хэлэлцэх асуудал. Хоёр.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 63 дугаар тогтоолоор байгуулсан “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орох хүсэлтээ ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ таныг саналаа танилцуулахыг урьж байна.

Тэгвэл Ж.Бат-Эрдэнэ гишүүн өөр Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа тул би энд ирүүлсэн бичгийг нь уншихъя.

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг Танаа,

Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу шийдвэрлэж өгнө үү.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ.

“Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцууллаа.

Сая гишүүний хүсэлтийг нь уншиж танилцууллаа.

Ингээд Түр хорооны тогтоолыг нь уншиж танилцууллаа. Уучлаарай, сая андуурсан байна.

Монгол Улсын Их Хурлын тогтоол.

“Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 80 дугаар тогтоолыг үндэслэн Хишгээгийн Нямбаатарыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдөр өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчит зарим компаниудын асуудлаарх Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчит зарим компаниудын асуудлаарх Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг нэмсүгэй.

3.Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Та бүхэнд тогтоолын төслийг уншиж танилцууллаа.

Хянан хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орох тухай санал болон Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй

холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Т.Доржханд гишүүн асуулт асууя.

Т.Доржханд: Баярлалаа. Нүүрсний хулгайтай холбоотой асуудлыг ярилцах, тэгээд нотлох баримтын хүрээнд нээлттэй сонсгол зохион байгуулах гээд ажил хийгдэж байна.

Тэгээд үүнтэй холбоотой гишүүн өөрчлөгдөж байгаа юм байна.

Сая тухайлбал Г.Дамдинням гишүүнтэй хальт санал солилцлоо. Тэгээд би яаж энэ нүүрсний хороонд орох вэ, ормоор байна гээд.

Тэгээд Г.Дамдинням гишүүний тэр мэдэгдэл нүүрсний хулгайн хамгийн том хэсэг бол төмөр замтай холбоотой хэсэг байна.

Үндэсний аудитын газрын дүгнэлт гарсан байна гээд мэдэгдэл хийсэн байна.

Тэгээд яалт ч байхгүй 18 их наяд төгрөгтэй холбоотой нууцалсан **off-take** гэрээний асуудал хамгийн том хэсэг нь байгаа.

Үүнтэй холбоотой материалуудыг үзье, харья гэхээр сөрөг хүчний зүгээс түр хороонд орсон гишүүдийн хувьд ямар нэгэн боломж байхгүй байна.

Өөрөөр хэлбэл хуучин өмнөх түр хороонууд дээр өөрийн судлаачид, хараат бус гишүүдийг оруулаад тэндээсээ мэдээлэл авдаг байсан бол энэ удаа тийм юм байхгүй болчихлоо.

Тэгээд ядаж бас ингээд олонх дээр үгээ хэлчихдэг, зоригтой хэлчихдэг, асуудлыг бодитой сөхөөд тавьчихдаг ийм

гишүүдийг оруулах асуудлыг ярих боломж байна уу гэж асууж байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол процессын хувьд тухайлбал Ж.Бат-Эрдэнэ гишүүн өөрөө санал гаргаад тэгээд ийшээ оръё гэж байгаа юу? Аль эсвэл танай бүлэг дээр ярьж байгаад оруулъя гэсэн үү гэдэг нэг асуулт байна л даа.

Тэгээд би Ж.Бат-Эрдэнэ гишүүний оронд Г.Дамдинням гишүүн гэж байгаа юм биш л дээ. Тухайлбал, ийм гишүүдийг нэмж оруулах боломж бололцоо байна уу?

Энэ дээр нам үл харгалзаад бид энэ том хулгайныхаа ард хамтдаа гардаг л байх ёстой.

Энэ нь нийгэмд хүлээлт авчирсан Монголын түүхэнд болсон хамгийн том дүнтэй авлига, хээл хахуулийн асуудал байгаа.

Одоо бид 12 сардаа багтааж хийхээс өөр арга байхгүй. Гэтэл энэ мэдээлэл маань нэгдүгээрт хаалттайгаар бүх асуудлууд яригддаг.

Хаалттай болохоор тэр доторх юмыг бид ярьж чаддаггүй. Нөгөө талдаа яг үүнийг ингээд зоригтойгоор яриад, өөрийн болон бусдын намын удирдаж байсан хүмүүстэй ч юм уу, эрх мэдэлтэй хүмүүстэй асуудлыг бодитоор ярьдаг ийм Улсын Их Хурлын гишүүд орох юм бол энэ үр дүнтэй байх болов уу гэж бодоод байна.

Тэгээд тэр агуулгаараа. Тухайлбал, энд ингээд орон зай гаргаад тэгээд зоригтой асуудлыг тавиад явчих ийм гишүүдийг оруулах боломж байна уу гэдэг дээр дахиад нэг хариулт өгөөч ээ. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Т.Доржханд гишүүний ерөнхий ярьж байгаа зарчмын талаас нь дэмжиж байна.

Тэгэхдээ та одоо энэ Хянан шалгах түр хороонд байгаа юм чинь хянан шалгах түр хороон дээрээ ярилцаад. Б.Энхбаяр сайд ахалж байгаа байх. Тийм ээ.

Б.Энхбаяр сайд, даргатайгаа яриад тэгээд гишүүн нэмье гэдэг саналаа Байнгын хороонд өгчих.

Тэгээд Байнгын хороон дээрээ дахиад цөмөөрөө хэлэлцээд явчихъя. Боломжтой гэсэн үг. Ер нь.

Харин хамгийн гол нь гишүүд маань идэвхтэй байх хэрэгтэй. Тийм ээ.

Байнгын хороон дээр баахан гишүүн нэмчхээд хуралдаа оролцдоггүй, идэвх гаргахгүй байгаад байж болохгүй.

Үнэхээр идэвхтэй оролцъё гэж байгаа гишүүд байвал бид дэмжээд оруулах нь зөв байх аа л гэж бодож байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Ингээд санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын

Их Хурлын гишүүн Т.Доржханд танилцуулна.

“Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийнхаа асуудалд оръё.

Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэх асуудал. Гурав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцаж эхэлье.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна. Х.Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Дарга аа, шалгах хугацааг жоохон сунгаж өгөхгүй бол ерөөсөө амжихгүй байна.

Сая бид төсөв хэлэлцэхээс өмнөх долоо хоногт ажлын хэсэг хуралдсан.

Тэгээд шаардлагатай нэмэлт мэдээллүүд бид тухайн сангууд болон аудитын газар луу явуулсан байгаа.

Аудитын хорооноос мэдээллүүд ирж эхэлж байна. Холбогдох сангуудаас

мэдээлэл ирэх ирээгүй байгаа. Тийм. Тиймээс бид ер нь 01 сарын 10 гэдэг хугацаа, 01 сарын 15 гэдэг хугацаа авчихъя. Дарга аа.

Завсарлахгүй шүү дээ. 15. Түүнээс өмнө амжуулна.

Ц.Цэрэнпунцаг: Санал, дүгнэлттэй холбоотой асуулт асуух, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Санал хураалт явуулж эхэлье.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтыг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гарах үүрэг бүхий Ажлын хэсгийн ажиллах хугацааг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл сунгахыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.
/алх цохив/

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй
танилцаж дууслаа.

Дараагийн асуудалдаа орё.

**Дөрөв.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний
түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл
болон хамт өргөн мэдүүлсэн**

*Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай,
Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай,
Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын
байнгын хороонд хүргүүлнэ/*

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулна уу.

Борхүүгийн Дэлгэрсайхан Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга, Пүрэвийн Сайнзориг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал

хариуцсан нэгдүгээр орлогч, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан Ахлах зөвлөх, Жалбажавын Бямбадулам Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Жаргалсайханы Ичинноров Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга, Насанбатын Мөнхбаяр Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга, Ганбатын Ганхүү Нийслэлийн Орон сууцын бодлогын газрын дарга, Чимэддоржийн Батзориг “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал, Доржготовын Хан-Уул Хот байгуулалт хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, Дангаагийн Авирмэд Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч, Маньбазарын Говьсайхан

Нийслэлийн Орон Сууцны Корпораци хувьцаат компанийн гүйцэтгэх захирал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийг баримтлан хуулийн төслүүдийг хэлэлцье.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Түгжрэл дээр нэг юм асуучихъя.

Хоёр, гурван заалт байгаа шүү дээ. Өрхүүдийнх нь 65 хувь нь хэрвээ санал өгчихвөл 35 хувийг нь одоо ингээд өгсөнд тооцоод газар чөлөөлнө гээд.

Тэгээд дээрээс нь таксины зөвшөөрөлтэй холбоотой нэг заалт байгаа. Тэгээд энэ заалтууд ер нь нэг юу яачихвал яасан юм бэ, П.Сайнзориг дарга аа.

Улсын Их Хурлын Тамгын газрын тэр экспертизийн хэлтэст өгөөд, Үндсэн хуультай харшилж байгаа эсэх. Юм байна уу, үгүй юү? Нэг дүгнэлт гаргуулчихвал яасан юм бэ.

Тэгээд нэг яаруу сандруу нэг хууль баталдаг. Дараа нь цэц рүү дуудагдаад л, тэгээд хуулиа хэрэгжүүлж ч болдоггүй. Тэгээд бүтэн жил шүүх, цэцээр явсан юм болчих вий дээ.

Ер нь иргэдийн ярьж байгаа нь тийм тал дээр нэлээн л хүчтэй дуугарцаагаад байна шүү дээ. Тийм ээ.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс, ажлын хэсэг хэд байна? Ажлын ажлын хэсгийн 2 номер микрофоныг өгье. П.Сайнзориг дарга хариул даа.

П.Сайнзориг: Х.Ганхуяг гишүүний асуултад хариулья.

Яг таны хэлж байгаа асуудал дээр бас бид хэд яг ингэх ёстой, тэгэх ёстой гэж хэлэх ямар ч эрхгүй. Энэ талаар бас тэгэх ёстой ч гэж хэлэх зохимжгүй л дээ.

Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарсан байна лээ. Г.Амартүвшин гишүүнээр ахлуулсан. Улсын Их Хурлын нэлээд олон гишүүд бас дотор нь байгаа.

Магадгүй ажлын хэсэг болон холбогдох Байнгын хорооноос уг асуудлаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасныхаа дагуу асуудлыг тавьж болох байх гэж бодож байна.

Энэ асуудал нь нээлттэй болов уу. Яг бид хэдийн зүгээс ингэх ёстой юм байна, тэгэх ёстой юм байна гэж таны асуултад шууд хариулж чадахгүй байна.

Тэгэхдээ ер нь зүгээр уг асуудал жишээ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дээр. Тийм ээ. Монгол Улсын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ер нь хүний эрх эрх чөлөөг хангахуйц нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг төр өөрөө бүрдүүлэх ёстой. Энэ хүрээндээ л энэ асуудлыг тавьж байгаа.

Эргээд бас тодорхой хэмжээний хүний эрхийг хязгаарлах бол хуулийн хүрээнд хязгаарлах ёстой.

Эргээд нийгмийн зайлшгүй хэрэгцээнд тодорхой хувь хүний эд хөрөнгийг дайчлан авахаар бол нөхөн

олговор олгож, үнийг төлнө гэсэн энэ заалтын хүрээнд л уг асуудлууд яригдаж байгаа.

Тэгэхээр Улаанбаатар хотын тулгамдсан асуудал ч тэр, ер нь иргэн талдаа, аж ахуйн нэгж талдаа ч тэр бас энэ асуудлууд нь өөрөө эргээд энэ замын хөдөлгөөний түгжрэл, орчны бохирдол, бас сууриар нь юмаа шийдье гэвэл энэ газрын менежментийн л асуудал байж байгаа. Үүнийгээ дагасан хот төлөвлөлтийн асуудал.

Тэгэхээр бид хэд энэ тойрог зам ч байдаг юм уу, метро, тэгээд тодорхой гэр хорооллын дэд бүтцүүдийг татчихсан дэд төвүүдийг яг тодорхой хэмжээнд эдийн засгийн эргэлтэд оруулья гэх юм бол одоо бас газар чөлөөлөлтийн асуудал зайлшгүй яригдаж байгаа юм.

Магадгүй Сэлбэ, Баянхошуу дэд төв дээр **ADB** [Asian Development Bank]-ийн тусламжтайгаар 100 сая төгрөгөөр дулаан цахилгааныг татчихаад байдаг. Ашиглалт дөнгөж 20 хүрэхгүй хувьтай явж байгаа. Энэ зээлийн маань тоолуур гүйгээд л явж байгаа. Бид хэд ашигладаггүй.

Жишээ нь, Сэлбэ төв дээр одоо 37-хон аж ахуйн нэгж ашиглаж байх жишээтэй. 37 нэгж, байгууллага ашиглаж байгаа учраас дулааны үнэ хотын төвөөс 3 дахин үнэтэй байх жишээний.

Тэгэхээр яах аргагүй л уг асуудлуудыг шийдэхийн тулд эдийн засгийн таталцал бүхий гэр хорооллыг цаашдаа орчны бохирдолгүй орчин болгохын тулд энэ одоо орон сууцжуулах бодлогыг нэн тэргүүнд нийслэлээс барьж байгаа юм.

Тэгээд энэ хүрээндээ энэ асуудлууд яригдах байх. Зүгээр таны яг

гаргаж тавьж байгаа саналтай холбоотойгоор би яг заавал тэр нэгжээр орох хэсэг дээр бол хариулж чадахгүй байна.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Одоо яах вэ, түгжрэлээ бууруулахад чинь бид дээр бас ажлын хэсэг дээр танд хэлж байсан. Та бүхэн судалсан уу, судлаагүй юу?

Яах вэ, газар нутгийн хувьд Сингапураас 10 хувь дахин том байдаг. Сингапур чинь өдөрт. Улаанбаатар хотыг ярьж байгаа шүү дээ.

Сингапурт чинь өдөр болгон 4500-аас 5000 мянган автобус яваад байдаг.

Бид одоо байгаа мянган автобусаа сүүлийн 10 жил, 20 жил хэрэглэж байгаа байхгүй юу.

Тэгээд шинэчлэлээ гэж бодоход хуучин автобус хүлээдэг байсан бол одоо зүгээр шинэ л автобус хүлээх гээд байгаа байхгүй юу. Тэгээд нөгөө нэг автобус хүлээдэг цаг ерөөсөө буурах юм харагдахгүй байхгүй юу. Нөхцөл байдал.

Хоёрдугаарт, хасах 30 градууст хүлээдэг асуудал чинь хэвээрээ л байх гээд байгаа юм.

Тэгэхээр нэгдүгээрт автобусны тоог нэмэгдүүлэх, дулаан зогсоол нэмэх.

Тэгээд энэ хотхонуудын тэр газрууд дээр нь зоригтойхон шиг тэр сургууль цэцэрлэгийн, сургуулиудын асуудлыг шийдэж болдоггүй юм уу?

Тэгээд одоо үүнийг хэдэн ч удаа хэлэх юм.

Алтай хотхон дээр одоо нэг аль нөгөөд энэ жил, хавар одоо жагсаал хийгээд л танайх руу хүсэлт өгсөн.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Асуултад гүйцээж хариулъя. 2 номер. Ажлын хэсгийн 2 номер.

П.Сайнзориг: Тийм ээ, тантай санал нэг байна. Одоо энэ автобуснуудыг 10, 10 жилийн хугацаатай л Засгийн газар хөрөнгө мөнгийг нь шийдэж өгдөг. Нийслэл үүнийг нь менежментээр авч явж чадахгүй ийм нөхцөл байдалтай байгаа нь үнэн.

Тэгээд энэ удаад бас үүнийг одоо өөрчилье өө. Энэ орж ирж байгаа автобуснуудаа тендер худалдан авалтын хуулийн дагуу авчхаад цаашдаа үүнийгээ түрээсэлж олсон орлогоор нь жил болгон автобусаа тодорхой хэмжээнд нэмээд явдаг, сайжруулаад явдаг энэ зүйл рүүгээ л орохгүй бол одоо 10, 10 жилийн циклтэй л ийм зүйлүүд болж байгаа. Үнэн.

Тэгээд үүнийг зайлшгүй шийднэ. Тэгээд мэдээж автобусаар зорчих энэ асуудлыг нэмэгдүүлэхийн тулд төлбөрийн уян хатан системийн асуудал байна.

Эргээд автобусны буудлуудын аятай тухтай нөхцөл байдлыг бүрдүүлэх асуудал байгаа юм. Тэгээд үүнийг бас одоо эзэмшиж байгаа хувийн эзэмшлийн компаниудтай нь ярьж байгаа.

Ядаж нөгөө техникийн хэллэгээр хацартай автобусны буудлууд хийгээч ээ гэж байгаа юм. Салхи, бороо, шорооноос жоохон хамгаалчихдаг.

Тэгэхгүй дээрээ нэг ийм самбар, хойд талдаа нэг ийм хашлага тавьчхаад л

зарын самбар шиг ажиллаж байгаа. Ядаж байхад автобуснуудын хуваарь мэдээлж.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Зарчмын зөрүүтэй саналууд ирээгүй байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй санал алга байна. /алх цохив/

Гишүүд ээ. Нөгөө дагаж орж ирсэн тухайн тухайн хууль дээрээ асуулт, санал байвал хэлээрэй.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон

сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналууд гараагүй байна. /алх цохив/

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй санал алга байна. /алх цохив/

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Х.Ганхуяг гишүүн Ч.Хүрэлбаатар гишүүн. Нэр тасаллаа.

Ч.Хүрэлбаатар гишүүн асуултаа асууя.

Ч.Хүрэлбаатар: Нэг л асуулт асуух гэсэн юм. Энэ Зөвшөөрлийн тухай

хуулиар такси эрхлэх зөвшөөрөл өгөх гэж байна даа? Тийм ээ.

Тэгэхээр П.Сайнзориг дарга аа, энэ дээр зүгээр ингэж болдоггүй юм уу? Зөвшөөрөл өгөхгүйгээр зүгээр стандартыг нь тавиад л, тэгээд компаниуд нь өөрсдөө такси компани болоод л явна биз. Тэгэхгүй бол зөвшөөрөл, нэг бичиг авдаг байхаар бол тэгээд л тэр нэг бичиг өгдөг, зөвшөөрөл өгдөг, хүний эрх мэдлээр шийдэгддэг юм болчихно шүү дээ.

Тэр стандартыг нь тавих хэрэгтэй. Ийм ийм машинтай байх ёстой. Ийм ийм байх ёстой.

Тэгээд ийм бол тэгээд шууд бизнесээ тэрүүгээ хийгээд л явдаг байхаар зохицуулж болох уу?

Яагаад вэ гэхээр түрүүний асуулттай л би холбоотой хэлж байна л даа. Автобусны буудал.

Бид энэ автобусны буудлыг нь ингээч тэгээч гэж, ийм болгуулах гэж байгаа юм, тийм болгуулах гэж байгаа юм гэж яриад байгаа юм.

Зүгээр автобусныхаа буудлуудыг стандартыг нь яг ийм ийм байх ёстой байна гээд заагаад өгчихгүй юу. Тэгвэл хэн нэгэн хүнээс шаардаад байх юм байхгүй. Тэр стандартынхаа дагуу л явдаг.

Өөрөөр хэлбэл энэ зөвшөөрлүүдийг нь стандартыг нь л ийм стандарттай бол энэ төрлийн бизнес эрхэлж болно оо ч юм уу, эсвэл ийм буудал нь ийм байна гэдгээ заагаад өгчих боломжтой юм биш үү?

Тэгэхгүй бол зүгээр л хуучин аргаараа тэрийг хийхийн тулд надаас

зөвшөөрөл авах ёстой гэнэ. Тэгээд л ямар ч хүмүүс нь зөвшөөрлийг нь авах юм билээ.

Энгийн бизнес эрхэлбэ гэж байгаа, бодож байгаа хүмүүс тэр зөвшөөрлийг нь авч чадахгүй шүү дээ.

Улаанбаатар хот бол сая ногоон автобус оруулж ирж чадахгүй л байна шүү дээ. Хэдхэн автобус оруулж ирж чадахгүй байж тэгээд нэг их олон юм хийж чадах юм уу? Тэгээд улс даяар Монголынхоо ард иргэдийг бүгдийг нь бухимдуулаад.

Тэгэхээр би энэ зөвшөөрөл өгдөг зүйл нь өөрсдөө одоо ийм чадамжгүй байгаа хүмүүс дээр эрх шилжүүлэх ийм шаардлага байгаа юм уу? Зүгээр стандартыг нь тогтоочих. Тэгээд өөрсдөө тэр стандартынхаа дагуу бизнес эрхлээд явчхаж болдоггүй юм уу гэдэг ийм л асуулт байна.

Ц.Цэрэнпунцаг: Асуултад ажлын хэсгийн 2 номер хариулах уу? П.Сайнзориг дарга хариулья.

П.Сайнзориг: Ч.Хүрэлбаатар сайдын асуултад хариулья.

Ер нь такси үйлчилгээний асуудал маань стандарттай байгаа. 2013 онд батлагдсан стандарт байдаг.

Энэ стандартыг барьж ажиллах асуудал хангалттай бус нөхцөл байдалтай байгаа.

Засгийн газар дээр хэлэлцэх явцад нийтийн тээврийн үйлчилгээг тодорхой зөвшөөрөлтэй болго оо.

Нэгдүгээрт яах вэ, энд бас иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах гэдэг юм уу, зорчих.

Эргээд энэ үйлчилгээ авах эрхэд халдагдаад байгаа зүйл байгаа. Таксинд маш олон янз бүрийн гэмт хэргүүд гарч байгаа. Таксины жолооч маань өөрөө хохирч байгаа. Таксинд зорчиж явсан иргэд маань таксины хувийн үйлчилгээ хийж байгаа хүмүүсийн халдлагад өртөж байгаа зүйл байгаа. Энд хүчингийн, хүн амины хэрэг, хүүхэд хулгайлах ч гэдэг юм уу маш олон гэмт хэргүүд гарч байгаа.

Тэгэхээр энэ дээрээ бид хэд тодорхой хэмжээний нэгдсэн компани гэдэг юм уу, одоо **“UBCab”** шиг компаниуд үүгээр яг албан ёсоор зөвшөөрлөө аваад л ажиллана гэсэн үг.

Такси баазтай байж болно, баазгүй байж болно. Гол нь эргээд энэ стандарт, камержуулалт, эргээд энэ зорчигчийн аюулгүй байдлыг хангах, энэ хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийнхээ асуудлуудыг цэгцтэй авч явах, бүртгэлтэй авч явах энэ л ерөнхий шаардлагуудыг тавьж өгч байгаа юм.

Түүнээс биш яг хүндрүүлье гэсэн бодол байхгүй. Тэгэхдээ ер нь зүгээр Ч.Хүрэлбаатар сайдын хэлж байгаа үнэн. Аль болохоор л төрийн зохицуулалтуудыг боломжийн хэмжээнд нь хийж энэ шаардлага стандартыг мөрдүүлэх ёстой.

Тэгэхээр стандартын хувьд жоохон болж өгөхгүй, хэрэгжихгүй талууд байна.

Тийм учраас тодорхой хэмжээний шаардлагууд тавья гэж байгаа юм.

Тэгэхээр яах вэ, магадгүй такси үйлчилгээнийх нь тодорхой хувь нь **carpooling** [ажил, сургуульдаа хамт зорчих] хийх

бололцоотой том хэмжээний **van**_[микроавтобус]-ууд, дунд хэмжээний **van** байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилдэг такси бас 5 хувь нь эзлэх ч гэдэг юм уу тодорхой ийм стандартууд бариулж байж нэг гэр бүлийн 6 хүнтэй хүн гараад такси барихад 2 таксинад хуваагдаж суухаар болчихоод байгаа байхгүй юу.

Гэх зэрэг такси үйлчилгээнүүдийг зах зээл дээр ажиллаж байгаа үед тодорхой менежмент хийж авч яваач л гэдэг ерөнхий ийм шаардлагуудыг тавих гэж байгаа юм.

Гол нь тэгээд бүртгэлжүүлэх л асуудал байгаа. Ингэж байж такси үйлчилгээний хариуцлагатай, үүнээс үүсэж байгаа сөрөг нөлөөлөл.

Мэдээж энэ чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа этгээдүүдийг зөвшөөрөлтэй такси бааз руу шилжиж ажиллах зохицуулалт нэлээдгүй байгаа.

Тэгэхээр энэ дээр уян хатан, бололцоотой байдлаар бизнесийн үйл ажиллагаанд төр хутгалдаад байхгүйгээр зохицуулалтыг нь хийгээд явъя л гэсэн бодолтой байгаад байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар гишүүн тодруулж асууя.

Ч.Хүрэлбаатар: П.Сайнзориг даргын зөв болгох гэж байгааг дэмжиж байна.

Гэхдээ ийм л баймаар байх юм. Тусгай зөвшөөрөл гээд гэх юм бол стандартаа хангачихсан хүн хэн нэгэн хүнээс хамаарахгүйгээр шууд л тэр зөвшөөрлөө авдаг болмоор байгаа юм.

Тэгэхгүй бол заавал нэг даргын гарын үсэг хүлээгээд, эсвэл тэр нь шийд гээд ингэх юм бол ер нь л том завхрал гарна шүү. Энэ чинь хаа сайгүй салбаруудад байгаа.

Тэгэхээр хүний гарын үсэггүйгээр шууд цахимаар ч байдаг ч юм уу. Тийм ээ. Ийм ийм зүйлүүд бий боллоо. Машин дотор ийм камер байна, эсвэл гудамжаар камержуулах ажлыг бол нийслэл хийчих байх. Гэх мэтийн юмнуудаа хийгээд л явчихдаг.

Өөрөөр хэлбэл тэр зөвшөөрөл авахад их амар байхаар стандарт хийвэл автоматаар тэр нь зөвшөөрлийг нь олгодог байх талаасаа бодно шүү л гэж хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Сая ерөнхийдөө санал юмыг хэлчихлээ. Тийм ээ. Х.Ганхуяг гишүүн та асуулт асууя.

Х.Ганхуяг: Зөвшөөрлийн хуультай холбоотойгоор нэгдүгээр асуулт.

Зөвшөөрлийн тоог нэмэхийн тулд нээлттэй сонголт хийх ёстой. Оролцогч талуудыг оролцуулаад нээлттэй сонголт хийсэн эсэх.

Нээлттэй сонголын үр дүнг Үндэсний зөвшөөрлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх ёстой. Зөвшөөрлийн зөвлөлийн үр дүн танилцуулагдах өгөх ёстой. Ингэж байж бид хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг ярих ёстой. Тийм ээ.

П.Сайнзориг дарга аа, та өөрөө манай ажлын хэсгийн нэлээн идэвхтэй гишүүдийн нэг байсан хүний хувьд үүнийг норм журмынх нь дагуу хийсэн болов уу гэж бодож байна.

Тэгээд энэ дээр нэг мэдээлэл авчихмаар байна.

Хоёрдугаарт, яг энэ түгжрэлтэй холбоотойгоор ерөөсөө ганцхан шийдэл л хэрэгтэй байгаа шүү дээ. Тийм ээ. Гараад л дулаахан зогсоолд байж байгаад гэрийнхээ хажууд сургууль, цэцэрлэг нь баймаар байгаа юм. 10 минутын зайнд.

Тэгээд автобусны буудал дээр даарахгүй байх ёстой. Тэгээд автобус нь 5-аас 10 минутын дотор ирдэг л байх ёстой.

Тэгэхээр та энэ дээр бодолцоод энэ хуульдаа оруулах юм уу, яах юм. Улаанбаатар хот өнөөдөр мянган автобусаар нийтийн тээврээ зохицуулах боломжгүй ээ. 3 мянга байх юм уу, 4 мянга байх юм уу.

Тэгээд тэр их хэмжээний мөнгөөрөө зогсоолуудаа бүгдийг нь дулаан зогсоол болго.

Гуравт нь, одоо ерөөсөө л нэн тэргүүн хийх ёстой ажил бол одоо тэр **“Алтай хотхон”**-оос авхуулаад тэр газруудыг нь чөлөөлөөд сургуулиудыг нь тавьж өг.

Бид улсын төсөв дээр сургуулийн төсвийг нь тавьдаг. Тэгээд энэ жил газрыг нь чөлөөлж өгч чадаагүйгээс болоод л нөгөө улсын төсөв дээр мөнгө нь буцаад л хасагдаад л явсан.

Тэр Яармагаар дүүрэн хотхонууд байна. Баянзүрх дээр 26 дугаар хороо гээд хороо байна. Манай Баянгол дүүрэг чинь одоо нэлээн хэдэн хороод байна. 3 хороо одоо сургууль, цэцэрлэггүй байна. Баянгол дүүрэг дээр.

Тэгээд үүнийгээ одоо шийдэхгүй л бол энэ түгжрэл шийдэгдэхгүй шүү дээ.

Тэгээд хүн хүүхдээ өглөө хасах 30 градуст дааруулан барин автобусанд суух гээд автобусаа хүлээгээд 30, 40 минут хүлээж суугаад зогсоно гэж байхгүй шүү дээ.

Та бүхэн амьдрал дээр юу болж байгаа, болохгүй бол хүн явуулаад судлуулмаар байгаа байхгүй юу.

Тэгээд дааруулахгүйн тулд яаж байна гэхээр сая төгрөгийн урьдчилгаа өгөөд, 2 сая төгрөгийн урьдчилгаа өгөөд л приусээ аваад л тэгээд л хүүхдээ хүргэж өгч байгаа байхгүй юу.

Тэгээд энэ шалтгаанд суурилсан бодлогоо цөмөөрөө хийж явахгүй бол яг л ингээд үр дагавар суурилуулаад л, тэгээд үр дагавар ярихдаа гэмт хэрэгтэй холбоод л яваад байхаар түгжрэл шийдэгдэхгүй л дээ.

Одоо таксиг зөвшөөрөлтэй болгосноор түгжрэлд ямар ч оролцоо байхгүй. Яг түүн дээр хийсэн судалгаа байхгүй. Зүгээр л нэг гэмт хэрэгтэй холбоод л. Ингэчих юм бол тэгэх болов уу гээд.

Тэгээд 200 мянган хүн сэлгүүцээд явж байна л гээд л байх юм.

Зах зээл дээр 200 мянган таксины эрэлт байна л гэсэн үг байхгүй юу. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүний асуултад П.Сайнзориг. Ажлын хэсгийн 2 номер хариулья.

П.Сайнзориг: Би сүүлийнхээс нь хариулья.

Такси үйлчилгээтэй холбоотойгоор тусгай зөвшөөрөлтэй болгосон нь яг түгжрэлтэй хамаатай юу гээд. Тодорхой түвшинд энэ хамааралтай болчихоод байгаа юм аа, гишүүн ээ.

Ер нь зүгээр яах вэ яг такси үйлчилгээг бас **“UBCab”** шиг ч гэдэг юм уу ийм загварын юманд оруулаад ирэхээр хүн хайж зам дээр холхих биш тодорхой хэмжээний дуудлагын дагуу яг зорьж очиж тухайн байршлаас нь хүнээ авна гэдэг бол эргээд энэ түгжрэл дээр бас нэлээн томоохон нөлөө үзүүлнэ.

“UBCab”-ын маань давуу тал тэр л байгаа юм. Тухайн машинууд зам дээр холхих биш тодорхой яг авто зогсоол дээр байж байгаад дуудлага ирлээ. Тухайн байршил руу яг зорьж очоод түгжрэл үүсгэхгүйгээр хүнээ аваад л дараагийн хүргэж өгөх газар дээр нь хүргэж өгч байгаа дээр л давуу тал байгаа юм.

Тэгэхээр уг асуудлуудыг такси үйлчилгээний аюулгүй байдал талаасаа ч тэр, хотын өнгө үзэмж ч тэр, дээрээс нь түгжрэл дээр ч гэсэн тодорхой хэмжээнд нөлөөтэй учраас хамаатуулж орж ирсэн гэдэг зүйлийг танд хэлье.

Хоёрдугаарт, сургууль, цэцэрлэгийн хүртээмж муу байгаа нь үнэн. Ер нь гэрээс гараад 15 минутын зайнд алхаад сургууль, цэцэрлэг, нийгмийн суурь үйлчилгээндээ авчих юм бол өнөөдрийн энэ түгжрэлийн асуудал тодорхой түвшинд шийдэгдэнэ.

Манай төрийн бүх байгууллагууд, соёлын байгууллагууд, боловсролын их дээд сургуулиуд, ер нь хувийн, төрийн гэлтгүй сургуулиуд бүгд энд Бага тойруу дотроо байгаа учраас өнөөдөр 5 байршлаас өглөө болгон 2.8 сая, 9 сая

зорчилт хийж яг энэ хотын төвдөө бид түгжирч байгаа.

Тэгэхээр гол асуудал нь сургууль, цэцэрлэг хайж л чанартай боловсролд хүүхдээ өгье гэсэн хүмүүсүүдийн зорчих хөдөлгөөн явж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр 91 мянган хүүхэд яг ойр орчимдоо сургуульгүйн улмаас өглөө болгон бусад дүүргийн гэдэг юм уу, холын хэсэг рүү зорчилт хийж сургууль цэцэрлэгт хүрэх гээд явж байгаа.

Тэгэхээр Боловсролын яаманд ч гэсэн бид хэд бас харилцан уялдаатай ажиллах ёстой. Одоо байгаа сургууль, цэцэрлэгүүдийг давхарлах тусам, давхарлаад хүүхдүүдийн тоог нэмэх тусам түгжрэлүүд нэмэгдэнэ.

Ингэж боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлж болохгүй. Бид хэд яг орчинд нь сургууль, цэцэрлэг барих бодлогыг цаашдаа уялдана.

Ер нь зүгээр ийм л байгаа. Яг мөнгө нь байхад газар нь чөлөөлж болохгүй тохиолдлууд байна. Хууль эрх зүйн тодорхойгүйн учраас.

Яг таны хэлж байгаа Баянгол дүүрэг дээр 3 байршил байгаа. **“Алтай хотхон”**-ыхон газраа өгөхгүй гэдэг. **“Материал импекс”**-ийнхэн болохоор цаад булан руугаа зааж өгчхөөд байгаа.

“Хурд” хорооллын дунд байгаа нэг байршил байгаа. Хоёр компани маань газраа өгөхгүй гэдэг.

Тэгээд энэ хууль гарвал нийгмийн зайлшгүй хэрэгцээнд компаниудтай ярилцаж газрыг чөлөөлж авч, тодорхой

хэмжээний сургууль, цэцэрлэг барих асуудал яригдана.

Жишээ нь, **“Алтай хотхон”** маань 12 мянган хүнтэй. 12 мянган этгээдийн цэцэрлэг байгаа, сургууль байхгүй.

Тэгэхээр энэ сургуулийг нь шийдээд өгөх юм бол замын хөдөлгөөний түгжрэлд тодорхой хэмжээний жишээ нь нөлөө үзүүлэхээр байж байгаа.

Уг асуудал одоо орж ирж байгаа нь уялдаатай. Энэ хуулиуд маань ингээд явж байгаа шүү гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд зөвшөөрлийн асуудлууд хуулийн дагуу явагдсан. Бид **“Худалдаа, аж үйлдвэрийн танхим”**-ын яг энэ чиглэлийн бизнес эрхлэх этгээдүүдтэй танхимаар дамжуулж харьцаж байгаа. Яг тухайлан компаниудыг дуудах биш.

Тэгэхээр ийм зүйлүүдийг хийгээд зохих журмын дагуу хуулийг хэлэлцүүлээд явж байна.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүдийн саналтай санал нийлж байна. Нэмээд санал хэлье гэж бодож байна.

Ер нь энэ хуулийг бид хамгийн гол нь хот өөртөө эрх мэдэл авч тодорхой хэмжээний тулгамдсан асуудлуудыг цаг алдахгүй нийтийн эрх ашгийн төлөө шийдчих асуудлуудаа олж харж оруулж ирж байгаа байх.

Ер нь гишүүдийн хамгийн гол нь анхаарал тавьж хандуулаад байгаа юм нь аль болохоор зах зээлийнх нь харилцаан дээр суурилсан, хүмүүсийг тэр зөвлөл хийх чиглэл рүү нь өдөөж өгсөн ийм бодлого илүү барьж ажиллах нь хэрэгтэй

шүү гэж Та бүхэнд анхааруулж хэлээд байна.

Бүхнийг захиргааны аргаар, зөвшөөрөл, лиценз олгох, хязгаарлах гэсэн бодлогоор энэ бүхнийг зохицуулж чадахгүй байх.

Энэ дээр зэрэгцүүлж зөөлөн бодлого явж байх ёстой шүү гэдэг талаас нь гишүүд анхаарч хэлж байгаа зүйлүүд их байна шүү.

Энэ дээр та бүхэн анхаарч бодлогоо гаргаж ажиллах хэрэгтэй байх. Хот.

Дээрээс нь хамгийн гол нь одоо бид нэг хууль гаргахдаа мэдээж хуулийн өмнө судалгаа гээд нэг юм дагаж орж ирдэг. Энэ бол хангалтгүй явдаг шүү дээ.

П.Сайнзориг дарга та өдөрт хэдэн сая зорчилт хийж байна гээд л нэг тоо ярьж байна. Энэ тоо бол тэгээд л нэг багцаатай л бодож байгаа л тоо.

Судалгааныхаа ажлыг сайн хийж байж, энэ дээрээ баттай ноттой үндэслэж суурилж энэ бодлого, энэ хууль, энэ дүрэм, журмаа боловсруулж байвал бидэнд бас их хэрэгтэй үр дүн гарах. Зорьж байгаа үр дүндээ хүрэхэд тус дөхөм болох юм болов уу гэж ярьж байгаа шүү.

Тэгэхээр дараагийн хууль, дүрэм журмаа боловсруулахдаа суурь судалгаагаа маш цэгцтэй, болж өгвөл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, олон их дээд сургууль, гадаадын дээд сургуулиудад ялангуяа программ болгоод, хөтөлбөр болгоод энэ чиглэлээр нарийн мэргэшсэн, тэр үр ашиг, зардлын тооцоо боддог аргачлал, үүнийг заадаг хөтөлбөрүүд хүртэл ихэсчихсэн.

Энэ чиглэлээр хүмүүс ажиллуулж, одоо тэр хотынхоо өөрийн нөөц бололцоог ашиглаад, энэ төрийн бус байгууллага, гаднын байгууллагуудын дэмжлэгийг аваад судалгаагаа сайн хийж байгаач ээ л гэж олон гишүүд яриад байна шүү.

Энэ бүхэнд цаашдаа анхаарч ажиллаарай гэж Байнгын хорооны зүгээс Та бүхэнд анхааруулж санал хэлье.

Асуулт асууж дууслаа. /алх цохив/

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй санал алга байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй санал алга байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон

сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн **Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн **Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн М.Оюунчимэг Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулна.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Та бүхэн гарч болно.

Тав. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
*/Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/*

Сүүлийн хэлэлцэх асуудал. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулна уу.

Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ч.Ундрам танилцуулна.

Ч.Ундрам гишүүний микрофоныг нээе.

Ч.Ундрам: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Төв банкнаас 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тогтоолын төслийг байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, гишүүдээр

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Доржханд, С.Чинзориг нар ажиллалаа.

Ажлын хэсэг Монголбанктай хамтран “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан заалт, зорилтуудыг танилцуулах уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Монгол Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Бизнесийн зөвлөл, Монгол дахь Америкийн Нэгдсэн Улсын Худалдааны танхимын бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцуулсан уулзалтуудыг зохион байгуулсан.

Тогтоолын төсөлд Засгийн газраас эрх зүйн орчныг бүрдүүлж, орон сууцын ипотекийн хөтөлбөрийг шилжүүлэн авах хүртэл хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх.

Мөн орон сууцын ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэнцүү хуваарилах, агаар, орчны бохирдлыг бууруулах, төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц, гэр хорооллын барилгажуулалтад олгох ипотекийн зээлийн хэмжээг хөтөлбөрийн нийт эх үүсвэрийн 20 хүртэл хувьд хүргэх арга хэмжээ авах.

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ажлын байрыг

нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бизнесийн зээлийг нэмэгдүүлэх, хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Банкнаас жижиг, дунд бизнест олгосон зээлийг ангилах, ангилал дээшлүүлэх, түүний бүтцийг өөрчилж дахин санхүүжүүлэх зохицуулалтыг эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчимд тулгуурлан уян хатан болгох ажлыг судлан шийдвэрлэх зэрэг зарчмын зөрүүтэй 6 саналыг бэлтгэлээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Ундрам гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Б.Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Г.Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Д.Ган-Очир Монголбанкны Ерөнхий эдийн засагч, Э.Анар Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал, Б.Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал, Э.Борхүү Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал, А.Энхжин Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал, Д.Ариунаа

Монголбанкны хэвлэл мэдээллийн ажилтан.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуултай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Б.Батгөмөр гишүүнээр, Ч.Хүрэлбаатар гишүүнээр тасаллаа. Т.Доржханд гишүүн асуултаа асууя.

Т.Доржханд: Баярлалаа би өөрөө ажлаа хийсэн гишүүн л дээ.

Тэгэхээр асуулт байхгүй. Ажлын хэсэг дээр нэлээн ярилцсан. Тэгэхдээ нэг зүйлийг тэмдэглээд хэлчихмээр байгаа юм.

Ирэх жил маш их өндөр тэлсэн төсөвтэй жил. Нэг.

Хоёрдугаарт, сонгуулийн жил. Хоёр.

Гуравдугаарт, манай инфляцын онилж байгаа бодлого 6 дээр хасах нь 2 буюу 8 дээр. Бас өмнөх уламжлалт байдлаар зорилт тавиад яваад байгаа.

Үүнийг л би хэлчихмээр байгаа юм. Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ хандаад.

Юу вэ гэхээр энэ зорилт ирэх жил биелэх магадлал маш бага. Биелэхгүй. Инфляц маш өндөр байгаа.

Ирэх жил манай судлаачдын тооцоогоор 15 орчим хувьд байх болов уу гэдэг хүлээлттэй байгаа.

Тэгээд гадаад орчин бас таагүй байгаа. Гадаад орчин, дайн байлдааны асуудал, дээрээс нь Хятадын эдийн засгийн нөхцөл байдал, төсөөлөл нь өөдрөг биш байгаа.

Үл хөдлөх салбарынх нь уналт, эдийн засгийнх нь саармагжилт. Энэ нь цаашаа эрэлтийг өсөх үү, үгүй юу гэдэг асуудал байгаа. Тийм.

Үүгээр юу хэлээд байна гэхээр төсөөлөл нь болохоор инфляц болоод ханшийн тогтвортой байдал тийм эмзэгхэн юм.

Ийм тохиолдолд бид маш өндөр хүүтэй орчинд ирэх жил амьдрах нь. Бодлогын хүү 13 хувиас бууна гэж бодохгүй байна. Нэг.

Тэгээд инфляц нам доор түвшинд байна гэж тийм өөдрөг төсөөлөл байхгүй байна.

Тэр тохиолдолд юу вэ гэхээр хатуу мөнгөний бодлого чинь үргэлжлэх нь байна шүү. Тийм.

Хатуу мөнгөний бодлого үргэлжилж байгаа ийм цаг хугацаанд элдэв нэртэй гоё төслүүдийг санхүүжүүлэхгүй бол болохгүй нь. Тэгээд сонгууль угтсан янз янзын өмнөх гоё гоё нэртэй эх үүсвэргүй, эх үүсвэрийг нь Монголбанк шийдье гэсэн байдлаар явах вий гэдэг болгоомжлол байгаа.

Үүнийг би ажлын хэсэг дээр ярилцсан байгаа. Тийм зүйлийг Монголбанк хүлээж авахгүй. Бид санхүүжүүлэхгүй гээд.

Ипотекийн зээлийг бид нэмэлт эх үүсвэрээр мөнгө хэвлэх байдлаар санхүүжүүлэхгүй гээд Сангийн сайд нь бас үгээ тов тодорхой хэлсэн байгаа.

Үүгээрээ юу хэлэх гэж байна гэхээр цаашаагаа эдийн засгийнхаа орчныг тогтвортой байлгах нь л хамгийн чухал бодлого. Энэ дээр Монголбанк мөнгөнийхөө бодлогын зорилтыг хангах

түвшинд илүү их институцийн хувьд ажиллах ийм үүрэг, чиглэл аваад орж ирж байгаа шүү. Үүнийг мэдэгдэх нь зүйтэй байх.

Тэр агуулгаараа энэ төсөл дээр нь үг, үсгийг нь засаад дэмжээд ажилласан байгаа.

Тэгээд ирэх жил Монголбанк энэ мөнгөнийхөө бодлогын зорилтыг хангахгүй тохиолдолд яах вэ гэдгээ бүгдээрээ хуульд тусга.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Т.Доржханд гишүүн санал хэллээ.

Б.Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Ажлын хэсгээс гаргаж байгаа саналууд дээр асуулт алга байна.

Би мөнгөний бодлоготой холбогдуулаад хэдэн санал хэлье гэж бодсон юм.

Мөнгөний бодлого төсвийн хүрээний мэдэгдэл дээр үндэслэж хийгдсэн гэж би ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл 21. Тийм. 23 их наяд төгрөг гээд. Тийм ээ. Зарлага.

Гэтэл 27.3 их наяд болчхоод байна энэ чинь. Тэгээд **4.3 их наяд** төгрөгөөр Монгол Улсын төсвийн зарлага өсөж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Монгол Улсын өрийн хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний **60.0** хувьтай тэнцүү байгаа.

Тэгээд инфляцыг Засгийн газраас оруулж ирэхдээ **8.5** хувь гэсэн.

Та нар 6-аас 8 хувь. Тийм. Одоо 6 дээр нэмэх, хасах нь 2 хувь гээд ингээд 8 хувь дээд хязгаар нь.

Тэгээд инфляц нэмэгдэнэ. Би Т.Доржханд гишүүнтэй санал нэг байна. Зүгээр 15 нь юу юм зүгээр. Минимум нь 12 хувь орчим хувийн инфляц нэмэгдэнэ.

Төсвийн алдагдал 1.5 тэрбум байгаа. Өрийн удирдлагын хуулийн заалтуудын дагуу гадаад зээлийн дээд хэмжээ **3.4 их наяд** төгрөг Засгийн газар авч ашиглана.

Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн дээд хэмжээг 1.2 их наяд төгрөгөөр баталчихсан байгаа.

Өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад Засгийн газрын төлөх өрийн хэмжээ **3.3 их наяд** төгрөг байгаа. Засгийн газраас гаргах өрийн баталгааны дээд хэмжээ **3.5 их наяд** төгрөгөөр тус тус баталчихсан.

Тэгэхээр энэ маань юу гэхээр та нарын оруулж ирж байгаа мөнгөний бодлоготой огт нийцэхгүй байгаа юм л даа.

Тэгээд эндээс би юу гэж хэлэх гэж байна гэхээр та нөхдүүд төсвийн бодлого, та нарын оруулж ирж байгаа мөнгөний бодлогын уялдаа юу байна аа? Ямар эрсдэлүүд байна аа? Одоо илэн далангүй хэлээч. Яах ёстой юм? Ямар эрсдэлүүд байна?

Ер нь эдийн засгийн өгөөж гэдэг юм чинь “амьдралын чанарын дээшлэлт” шүү дээ.

Ядуурал буурна, дундаж хүмүүсийн хувь нэмэгдэх ёстой.

Инфляц гэдгээрээ дамжаад манай ядуурал гэдэг юм чинь нэмэгдээд яваад байгаа. Мэдээж **10 хувийн инфляц** гэдэг чинь **2, 3 их наяд төгрөг** иргэдийн халааснаас нэмээд суйлна гэсэн үг. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ханш дээр ямар төсөөлөлтэй байна?

Одоо энэ цаг дуусч байна. Алт дээр ямар тооцоо, судалгаа.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс 3 номер. Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Тийм. Төсөв бол нэлээн тэлэлттэй. Дотоодын нийт хүний бараг 37, 38 хувьтай тэнцэхээр зардалтай том төсөв явж байгаа.

Нэгэнт төсөв том тэлэлттэй байгаа учраас мөнгөний бодлогын хувьд мөнгөний бодлого хатуу үргэлжлэх өөр сонголтгүй л нөхцөл байдал байгаа.

Тэгээд бодлогын хүү өнөөдөр **13, инфляц** сая 10 сарын эцсийн байдлаар **9** хувьтай гарсан. Бодлогын хүү, инфляц хоёрын зөрүү **нэмэх 4** буюу бодит хүү **4** байгаа гэсэн үг.

Хэрвээ инфляц үнэхээр хоёр оронтой тоо руугаа буцаж ороод, сая Т.Доржханд гишүүний хэлж байгаа 14, 15 хувь гээд өндөр болох юм бол бодлогын хүү бодит байх ёстой гэдгээрээ цаашаа нэмэгдэхээс өөр гарцгүй л болно л доо. Тэр утгаараа мөнгөний бодлого улам

хатуураад л явахаас өөр сонголтгүй л байдалтай байгаа юм.

Монголбанк зорилтот түвшиндээ богино хугацаанд хүрэхийг л зорьж байгаа учраас бодлогын арга хэрэгсэл улам хатуу болоод явах байх л гэж харж байгаа.

Төлбөрийн тэнцэл сая 9 сарын 30-ны байдлаар **770.0** сая долларын ашигтай гарсан.

Энэ хэмжээгээр төлбөрийн тэнцэл эерэг байна гэдэг маань валютын нөөц нэмэгдэнэ.

Ханш тогтвортой байх боломжтой орон зайг бий болгож байгаа.

Тэр утгаараа 2023 оны оны эхнээс хойш валютын ханш ерөнхийдөө бараг сулраагүй. **0.6** хувьтай л суларсан гэх юм бол ийм хэмжээний бага байгаа.

Энэ утгаараа ерөнхийдөө 2023 он, 2024 оныг хэрвээ эдийн засаг, ялангуяа худалдааны тэнцэл, төлбөрийн тэнцэл ашигтай хэвээрээ үргэлжлэх юм бол ханш дээр өөрчлөлт орох, савлагаа үүсгэх дарамт байх байхгүй гэж Монголбанкны зүгээс харж байгаа.

Алтыг Монголбанк худалдаж авч ирсэн. Энэ оны хувьд ерөнхийдөө хэдийгээр 20 тонн алт худалдаж авах зорилттой байгаа ч гэсэн яг одоогийн байдлаар **15 тонн алт** авчихсан байна. Он дуустал нэг, хоёр сарын л хугацаа байна л даа. Тэр болтол 20 хүрэх магадлал багатай байгаа.

Тэгэхээр алтны худалдан авалт өнгөрсөн онуудын 20 тонноос илүү гарсан үетэй харьцуулах юм бол дутуу явж байгаа. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн тодруулж асууя. Б.Баттөмөр гишүүний микрофоныг нээе.

Б.Баттөмөр: 2024 онд бид маш хэцүү цаг үетэй нүүр тулах нь л дээ.

Яагаад гэхээр мөнгөний хатуу бодлого явна. Аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдэд ямар ч ээлгүй.

Өнөөдөр **18-аас 20 хувийн хүүтэй зээл** аваад бизнес хийдэг хүн гэж ерөөсөө байхгүй.

Дээрээс нь **8.5 хувийн инфляцтай үед бизнесийн орчин гэдэг байхгүй** л болох нь л дээ. Тэгээд үүнийг одоо яах ёстой юм. Цааш цаашдаа бодлогын тохируулга, энэ хоёр бодлогын хэрэгслээ хооронд нь уялдуулаад явах шаардлага үүсэж байна л даа.

Би юу гэж хараад байна гэхээр **“мөнгөний бодлого”**, **“төсвийн бодлого”** хоёрын хоорондын уялдаа ерөөсөө байхгүй л байна.

Уг нь төсвийг батлахдаа мөнгөнийхөө бодлоготой маш сайн уялдуулж нягталж батлах ёстой гэж ойлгоод байгаа.

Өнөөдөр ядуурал бууруулна гээд л үзэж байгаа юм. Хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлнэ л гэж байгаа юм. Ядуурал бууруулахын тулд инфляцаа л багасгах ёстой байгаа юм.

Инфляцийг чинь зарим газар **“татвар”** гэж хэлдэг, зарим газар одоо ерөөсөө **“халаасны хулгайч”** гэж байгаа шүү дээ. Тиймтээ.

Ямар ч байсан 2024 онд бид халаасаа суйлуулах нь.

8.5-аас 10 хувь нь инфляцтай байхад нь 2.5-аас 3 их наяд төгрөг нэмж иргэдийн халааснаас гарах нь.

Ийм тохиолдолд ард түмний амьдрал дээшилнэ гэсэн юм байхгүй л болох юм байна л даа.

Яах вэ, хөдөө, орон нутагт энд тэнд цалин нэмж байгаа. Харамсалтай нь нэмж байгаа цалин нь бүтээмжид суурилаагүй учраас инфляцаараа дамжаад буцаад л гарна. Ийм л байдалтай байгаа.

Тийм учраас бодлогын хэрэгслүүдээ нэгтгэж цоо шинээр сэтгэж.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн тодорхой саналууд хэллээ. Ч.Хүрэлбаатар сайд асуултаа асууя.

Ч.Хүрэлбаатар: Надад асуулт алга.

Ч.Ундрам гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг их сайн ажиллажээ л гэж би харж байгаа. Янз бүрийн хууль бус юм уу, инфляцыг хөөрөгдөх юм уу, ийм зүйлүүдийг бүгдийг нь засаад оруулаад иржээ гэж харж байгаа юм.

Тэгээд хоёр зүйл л хэлэх гэсэн юм.

Сая 2024 оны төсвийг батлахад эдийн засгийг хэтэрхий өөдрөг тооцсон байна гэдэг зүйл энд тэнд гарсан.

Тэгээд би одоо яг Монголбанкныханд хэлэхэд эдийн засгийг тийм хэт өөдрөг байдлаар тооцоолсон зүйл байхгүй байгаа. Яагаад вэ гэхээр ер нь улс орнуудынхыг аваад

үзэхэд ирэх жилүүдэд хүү өндөр байхаар байна. Өндөр байна гэдэг чинь хэрвээ бид төсөв дээр алдагдалтай яваад байх юм бол маш өндөр хүүтэй бонд босгоно, өндөр хүүтэй санхүүжилт авна гэсэн үг.

Тэгэхээр ирэх жил ер нь хүү буухгүй нь. **“Бодлогын хүү”** буухгүй нь гэдэг хүлээлттэй байх ёстой.

Дараагийн нэг зүйл нь **“инфляц”** байгаа юм. Инфляц бол яах вэ Америк болон бусад орнууд доошоо нэлээд буух тийм хандлагад орчихлоо.

Гэхдээ мөддөө бодлогын хүүнүүд буухгүй болов уу гэсэн бодолтой байгаа үед энд бодлогын тооцоогоо сайн хийгээрэй гэж байгаа юм.

Монголын хувьд юу вэ гэхээр бид нарын хувьд энэ Хятадын эдийн засгийн нөхцөл байдлаас их хамаардаг. Яг Монголтой хиллэдэг Хятадын ар талын бүс, мужийн эдийн засгийн өсөлтүүд их өндөр байгаа шүү дээ.

Өвөр Монголын эдийн засгийн өсөлт нь 7.2. Ийшээгээ эргээд бас нэг хэд хэдэн бүс байгаа. Бүгдийнх нь өсөлт 6.4-өөс дээшээ.

Хэдийгээр Хятадын эдийн засгийн өсөлттэй хүлээгдэж байснаас өндөр байгаа ч гэсэн яг Монголтой хиллэдэг бүс нутгуудын эдийн засгийн өсөлт өндөр байгаад байгаа нь манай эдийн засгийг өндөр өсөлттэй явчих боломжтойг харуулж байгаа.

Дараагийн нэг зүйл юу вэ гэвэл инфляцын түвшин нь Хятадад үндсэндээ хасах 0.2 дефляцтай байгаа. Инфляц бага байна гэдэг бол Хятадын хувьд бодлогын тийм их олон арга хэрэгслүүдийг авч хэрэгжүүлэх боломжтой, орон зай ихтэй.

Манайд инфляц өндөр учраас авч хэрэгжүүлэх бодлогын орон зай хумигдчихаад байна шүү дээ.

Тийм учраас бид нарын хувьд гадаад нөхцөл байдал Монгол Улсын эдийн засаг дээр аваад үзэх юм бол тийм муу биш, хэвийн гэж бид харж байгаа.

Монгол Улс өөрийнхөө экспортыг нэмчих боломж байгаа юм.

Төсвийн орлого ч гэсэн. Бид нэлээд нэмээд батлахад орлого даваад л биелж байгаа. Ирэх жил ч гэсэн нэг тиймэрхүү байдал харагдах болов уу гэсэн бодолтой байгаа учраас бодлогоо их зөв хэрэгжүүлээрэй л гэж би хэлмээр байна.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд тодорхой санал хэллээ. Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Өнөөдөр мөнгөний бодлого хэлэлцэж байгаатай холбоотой тэр төсөв мөнгөний бодлогыг нийлүүлэх, уялдуулах асуудал болоод бид мөнгөний бодлогоор хийх гэж оролдоно л доо.

Тэгээд одоо Ч.Хүрэлбаатар сайд байгаа дээр, мөнгөний бодлого хариуцсан хүмүүс байгаа дээр нь ганцхан зүйлийг хэлэх гэсэн юм.

Яах вэ, бид нарын бодлого энэ жил нэлээн зөв тийшээгээ цэгцрээд явчихлаа л даа. Бид экспортод алддаг байсан мөнгөө олж ирдэг боллоо. Гайгүй үнэтэйгээр зардаг болж байна. Хил дээр гацдаг байсан бараа, бүтээгдэхүүнээ зарж чаддаг болж байна. Гаргаж чаддаг болж байна гэсэн үг.

Тэгээд одоо үлдчихээд байгаа хоёр, гурван ажил байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр дотоодын хяналт шалгалтын

ажлыг нэлээн сайн эрчимжүүлмээр санагдаад байгаа юм.

Энэ бол нэн ялангуяа сангуудтай холбоотой асуудал байна. Үнийн хөнгөлөлттэй холбоотой асуудал байна. Тухайлбал, улаан буудайны үнэ ч дэлхийн ханш өнөөдөр 240-өөс 250 долларын хооронд хэлбэлзэж байхад манайх чинь тэр салбарт ажиллаж байгаа компаниудад нь бүх шатанд нь дотаци өгөөд 310, 320, доллар, 330 долларыг хооронд аваад байгаа юм.

Гэхдээ тэр авч байгаа улаан буудайн талханд, гурилд тэнцэх улаан буудай юм уу, спиртийн улаан буудай юм уу. Бүү мэд.

Тэгэхээр энэ дээр өгч байгаа мөнгөн дээрээ эргээгээд үр дүнг нь шалгадаг, тэгээд шахдаг. Тэгээд энэ татвар төлөгчдийн мөнгийг хэмнэдэг нэгдүгээр ажил бас хиймээр байгаа юм.

Хоёр дахь жишээ. Эрүүл мэндийн даатгалын сан гээд. Хүмүүсийг сувилал явуулж амраадаг мөнгө байгаад байх шиг байна. Манай тойрог дээр чинь алдартай нэг хүн бий. Нэг хүнийг арван хэдэн удаа амраачихсан байгаа юм.

Зарим хүмүүс нь арван хэдэн удаа сувилалд очоод амардаг. Зарим хүмүүс нь нэг удаа амардаг. Яг бодитойгоор амарсан юм уу, эсвэл зүгээр бичилт хийчихсэн юм уу. Мэдэгддэггүй.

Тэгээд төсвийн зарцуулалттай, төсвийн хяналттай холбоотой энэ асуудлыг яг бүр одоо Засгийн газрын хэмжээнд хянан шалгалтын ажлыг нэлээн сайжруулах шаардлагууд харагдаж байна лээ. Тэгж байж бид нарын яриад байгаа үнийн өсөлт, одоо яриад байгаа нь талхны үнэ өсчихлөө гээд л, сүүний үнэ

өсчихлөө гээд. Сүү чинь одоо өнөөдөр 3500 болж байх шиг байна.

Тэгэхээр энэ үнэ өссөн сегментүүд дээрээ зөвхөн нөгөө нийлүүлэлтийн аргаар биш, одоо нөөцийн махаар биш, яг тэр сегмент дээрээ яагаад үнэ өсчихсөн юм гэдэг нь илүү сайн шалгадаг баймаар байна. Одоо энэ инфляцад холбоотой бас Монголбанк ч хариуцдаг. Үнийг бууруулах тал дээр Засгийн газар ч хариуцан ажиллаж байдаг.

Тэгээд энэ дээр хамтарсан ажлын хэсэг байх юм уу? Зарим нэг тохиолдолд дотация багасгадаг, зохицуулдаг ийм хэлбэр лүү орохгүй бол болохгүй байна.

Эрүүл мэндийн даатгал ч тэр байна. Тэгээд олон хуримтлалтай нийгмийн даатгал ч байдаг юм уу, бусад сангууд чинь банкн дээр мөнгө хийгээд л алдчихдаг. Банкнууд дээр мөнгө хийгээд авчихдаг.

Тэгэхээр энэ дээр тэр төрийн мөнгийг хадгалахдаа яг аль аль банкн дээр хадгалах юм? Тэрийг эсвэл танайх зөвлөмж өгдөг байх юм уу? Ингэж явахгүй бол.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулъя.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Тогтоолын төсөлд 2 дугаар заалт нэмэх:

“2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

1/Засгийн газраас эрх зүйн орчныг бүрдүүлж, орон сууцны ипотекийн хөтөлбөрийг шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;

2/Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэнцүү хуваарилах;”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Г.Амартүвшин, Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Доржханд, С.Чинзориг Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал дээр асуулттай гишүүд байна уу? Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 3 дугаар дэд заалт нэмэх.

3/Агаар, орчны бохирдлыг бууруулах, төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц, гэр хорооллын барилгажуулалтад олгох ипотекийн зээлийн хэмжээг хөтөлбөрийн нийт эх үүсвэрийн 20 хүртэл хувьд хүргэх арга хэмжээ авах.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж,
санал дэмжигдлээ.

**3.Тогтоолын төслийн хавсралтын
1 дүгээр заалтад доор дурдсан агуулгатай
1.3 дахь заалт нэмэх:**

“1.3.Эдийн засгийн тогтвортой
өсөлтийг хангаж, ажлын байрыг
нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
зорилгоор бизнесийн зээлийг
нэмэгдүүлэх, хэрэглээний зээлийн хэт
өсөлтөөс сэргийлэх арга хэмжээг авч
хэрэгжүүлэх;”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 72.7 хувийн дэмжиж,
санал дэмжигдлээ.

**4.Тогтоолын төслийн хавсралтын
2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай
2.4 дэх заалт нэмэх:**

“2.4.Банкнаас жижиг, дунд
бизнес т олгосон зээлийг ангилал,
ангилал дээшлүүлэх, түүний бүтцийг өөрчилж,
дахин санхүүжүүлэх зохицуулалтыг
эрсдэлд суурилсан хяналт шалгалтын
зарчимд тулгуурлан уян хатан болгох
ажлыг судлан шийдвэрлэх;”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж,
санал дэмжигдлээ.

**5.Тогтоолын төслийн хавсралтын
3 дугаар заалтад доор дурдсан агуулгатай
3.3 дахь заалт нэмэх:**

“3.3 Тогтвортой хөгжлийн
зорилтын таксономид органик хүнсний
тариалалт, үйлдвэрлэлийн үйл
ажиллагааг тодорхой тусгаж, төрийн
дэмжлэгтэй хэрэгжиж буй зээл,
санхүүжилтийн хөтөлбөрүүдийн багцын
тодорхой хэсгийг тухайн таксономитой
уялдуулан ногоон, тогтвортой зээл
гаргадаг болох чиглэлээр санхүүгийн
байгууллагуудтай хамтран ажиллах;”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж,
санал дэмжигдлээ.

**6.Тогтоолын төслийн талаарх
зарчмын зөрүүтэй саналын томьёолол
дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн
бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс
дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг
нийцүүлж өөрчлөх.**

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж,
санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан
гишүүдийн бичгээр гаргасан саналын
томьёоллоор санал хураалт явуулъя.
Ирсэн санал алга байна.

Санал хураалт явуулж дууслаа.
/алх цохив/

“Төрөөс мөнгөний бодлогын
талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл
батлах тухай” Улсын Их Хурлын
тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг
явуулж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, үүгээр хуралдаан өндөрлөж байна.

Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Хуралдаан 1 цаг 12 минут үргэлжилж, 16 цаг 33 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД